

**СЭДЭВ: ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН ОЮУТНУУДЫН САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ**

Монгол банкны оюутны эрдэм шинжилгээний хуралд зориулав.

Гүйцэтгэсэн: Энх-Учрал, II түвшний оюутан/ Бизнесийн удирдлага/
Б.Ариунсайхан, II түвшний оюутан/ Нягтлан бодох бүртгэл/
Ш.Бүжинлхам, III түвшний оюутан/ Эрх зүй/

Удирдагч багш: Э. Тамир /Санхүү Эдийн засгийн Их Сургуулийн “хувь хүний санхүү” хичээлийн багш/

Цахим шуудангийн хаяг:

b19fa1049@ufe.edu.mn

b19fa1122@ufe.edu.mn

b18fa1607@ufe.edu.mn

Холбоо барих утас:

89176610

99502910

89329919

Улаанбаатар

2021 он

Товч хураангуй

Санхүүгийн боловсролыг маш энгийнээр хэн бүхэнд ойлгогдохоор тайлбарлавал хязгаарлагдмал мөнгийг үр ашигтай зарцуулах ухаан юм. Энэхүү ойлголт нь зөвхөн хувь хүнд бус тухайн улс орны эдийн засгийн үзүүлэлттэй салшгүй холбоотой байдгын хувьд орхигдуулж болшгүй чухал үзүүлэлт юм. Манай улсын хувьд санхүүгийн боловсрол олгох сургалт хөтөлбөрийг Монгол банк болон арилжааны банкууд бусад олон байгууллагууд зохион байгуулдаг хэдий ч тэдгээр нь бодит байдал дээр хэр үр дүнтэй байсан талаар судалгаа дутмаг байна гэж бидний зүгээс харж байна. Тиймээс бид иргэдийн санхүүгийн боловсрол тэр дундаа *их сургуулийн бакалаврын түвшний оюутнуудын* санхүүгийн боловсролыг үнэлж санхүүгийн боловсролын өнөөгийн байдлыг тогтоох зорилгоор түүврийн байдлаар 400-н иргэнээс анкетийн аргаар судалгаа авсан болно. Үүний үр дүнд санхүүгийн мэдээллийг түгээх сувгуудаа өргөжүүлэх шаардлагатай байгааг тодорхойлсон.

Түлхүүр үг

Санхүүгийн боловсрол, санхүүгийн мэдлэг, бакалаврын оюутнууд,

Агуулга

1. Онолын хэсэг

1.1 Санхүүгийн боловсрол гэж юу вэ? Түүний онцлог

1.2 Санхүүгийн боловсролын үе шат түүний хэлбэр, ангилал

1.3 Монгол улсын санхүүгийн боловсрол олгох байгууллагууд

1.4 Олон улсын санхүүгийн боловсрол олгох байгууллагууд болон тэдгээрийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

1.5 Дүгнэлт

2. Өнөөгийн байдал

2.1 Монгол улсын санхүүгийн боловсролын өнөөгийн байдал

2.2 Олон улс дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал

2.3 Их дээд сургууль дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал

2.4 Олон улсын их дээд сургууль дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал

2.5 Олон улсын их дээд сургуулиудын санхүүгийн боловсролд хийсэн үнэлгээ

2.6 Бүлгийн дүгнэлт

3. Судалгааны арга зүй

4. Судалгаа

4.1 Их дээд сургуулийн оюутнуудын дунд хийсэн судалгаа

4.2 Их дээд сургуулиудын багш судлаач нарт хийсэн судалгааны үр дүн

Дүгнэлт зөвлөмж

ОНОЛЫН ХЭСЭГ

1.1. Санхүүгийн боловсрол гэж юу вэ? Түүний онцлог

Санхүүгийн боловсрол гэдэг нь хувийн санхүүгийн менежмент, төсөвлөлт, хуримтлал зэрэг төрөл бүрийн ур чадваруудыг ойлгож, үр дүнтэйгээр хэрэгжүүлэх явдалыг хэлдэг. Хувь хүний санхүү нь хязгаарлагдмал мөнгөн орлого, зарлагаа хэрхэн оновчтой зөв удирдаж байгааг судалдаг шинжлэх ухааны салбар бөгөөд хязгаарлагдмал санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилах нь хувь хүний санхүүгийн үндсэн чиг үүрэг юм. (Монгол банк, 2021)

Олон улсад ажил олгогчийн зүгээс ажилчдадаа зориулж тэтгэмж тогтоох, тэтгэврийн төлөвлөгөөг гаргах, тэтгэврийн хэмнэлт, ажил олгогчоос ажилчдад хөрөнгө оруулах хариуцлагыг хүлээн ажиллаж бай на. (Lusardi, 2019)

1.2. Санхүүгийн боловсролын үе шат, түүний хэлбэр ангилал

Санхүүгийн боловсролыг дараах дэд сэдвүүдэд ангилан авч үзнэ.

№	Хэлбэр ангилал	Тодорхойлолт
1	Мөнгөний удирдлага	Мөнгийн хүн өөрийн хичээл зүтгэлийн үр дүнд цалин хөлс, шагнал, талбэр хэлбэрээр олохоос гадна хөрөнгө оруулалтаас ногдол ашиг, хүү хэлбэрээр олдог. Мөнгийг зээлж, зээлүүлж, хуримтлуулж, бэлэглэн, өвлүүлж, арилжаалж болдог. Түүнчлэн та зарцуулснаасаа илүүг олж, эсвэл багыг зарцуулах хэрэгтэй. (О.Ирвэс, 2019)
2	Өрхийн төсөв	Өрхийн орлогын ангилалд цалин хөлс, шагнал, хөрөнгө борлуулсны олз, сугалаа, бооцоот тоглоом, бусад зэрэг орно. Өрхийн орлого нэмэгдүүлэх боломж нь өрхийн аж ахуй эрхлэх, төсөл бичих, бизнес эрхлэх, төсөл, хөтөлбөрт хамрагдах, өрхийн гишүүдийг мэргэжил,

		мэдлэгтэй болгох, ажил хөдөлмөр эрхлэх, хуримтлалтай болох, хөрөнгө оруулалт хийх юм. (О.Ирвэс, 2019)
3	Банк, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа	Санхүүгийн байгууллага гэж санхүүгийн үйлчилгээ эрхэлдэг, санхүүгийн зуучлагчдыг хэлэх бөгөөд эдгээр нь зээл олгох, мөнгөн хөрөнгийг хадгалах, төлбөр тооцоо хийх, Монголбанк, Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлэхэд оролцох зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг. (Д.Оюунцэцэг, 2019)
4	Хуримтлал ба хадгаламж	<p>Хуримтлал үүсгэх алхамууд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Орлого ба зардлаа бүртгэх ➤ Хэмнэж болох зардлаа хасч орлого болон зардлын төлөвлөгөө гаргах ➤ Хуримтлал хийж болох хэмжээг тодорхойлох ➤ Хуримтлал хийх зорилгоо жагсаан бичих ➤ Урт богино хугацааны зорилгоос хамааран хуримтлалын хэлбэрээ сонгох ➤ Хуримтлалаа эхлүүлж, хэрхэн өсч байгааг хянаж байх <p>Мөнгөө хадгалуулах эрсдэл багатай арга бол банкинд хадгалуулах юм. Хадгаламж нь хугацаатай болон хугацаагүй гэсэн үндсэн төрөлтэй байдаг. (Д.Оюунцэцэг, 2019)</p>
5	Зээл	Санхүүгийн байгууллага, хувь хүнээс өөрийн хувийн хэрэгцээ болон бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтыг тодорхой хугацаатай, хүүтэй, эргүүлж төлөх нөхцөлтэй авахыг зээл гэж энгийнээр тодорхойлж болох юм.

6	Бүтээгдэхүүний үнийн өсөлт валютын ханш	Инфляцийг бид хялбараар бараа, үйлчилгээний үнийн өсөлт, мөнгөний худалдан авах чадварын бууралт гэж ойлгож болно. Хэрэв инфляцигүй байвал юмны үнэ өөрчлөгдөхгүй. Гадаад, дотоод төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа аль нэг улсын мөнгөн тэмдэгтийг валют гэнэ. Валютыг үндэсний болон гадаад валют гэж хоёр хуваана.
7	Хөрөнгө оруулалт, мөнгөө өсгөх арга	Хөрөнгө оруулалт гэдэг нь ашиг олох, хөрөнгөө өсгөх зорилгоор тодорхой нэг хөрөнгөд мөнгөө байршуулахыг хэлнэ. Хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө, банкны хадгаламж зэргээр хөрөнгө оруулалтын олон хувилбар бий.
8	Даатгал	Хүний амьдралд учирч болох тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, учрах хохирлыг хамгийн богино хугацаанд арилгах үр дүнтэй санхүүгийн арга бол даатгал юм. Даатгуулагч нь даатгалын компанид өөрийн ашиг сонирхлоо даатгуулсны төлөө хураамж төлдөг. Хураамж нь тухайн даатгуулагчийг эрсдэлд орсон үед хохирлыг нөхөх төлбөр, даатгалын компанийн үйл ажиллагааны зардал, ашгийг багтаасан төлбөр байна.
9	Татвар	Хувь хүн, байгууллагын олсон орлого, ашиг, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээнээс хуулинд заасан хувь хэмжээгээр авч, улсын төсөвт оруулж байгаа мөнгийг татвар гэнэ. (П.Баянсан, 2019, хууд. 139) Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь хувь хүний хөдөлмөр эрхлэх, хөрөнгө борлуулах зэргээр олсон бүх орлогод ногдох албан татвар юм. (П.Баянсан, 2019)
10	Тэтгэвэр	Тэтгэврийн даатгалд даатгуулсан бөгөөд өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол хангаж, тэтгэвэр тогтоолгосон хувь хүнд сар бүр, нас барсны дараагийн сар дуустал олгодог мөнгийг хэлнэ. Өндөр настны тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр гэж ангилна.

1.3 Монгол улсын санхүүгийн боловсрол олгох байгууллагууд

1. Монгол банк

- Монгол банк нь санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд сургалт, төсөл, хөтөлбөр, зохион байгуулж хэрэгжүүлдэг. Тэдгээрийн нэг нь “Төсөвчин” аппликэйшн юм. Энэ нь 9 бүлэг бүхий санхүүгийн суурь ойлголтыг оруулж өгсөн хялбар бөгөөд мөн санхүүгийн тооцоолууруудыг багтааснаараа сайн ач холбогдолтой. Энэхүү аппликэйшнийг үнэгүй татах боломжтой ба 2021 оны 4-р сарын 25-ний өдрийн байдлаар 10000+ хүн суулгасан бөгөөд 3+ үнэлгээтэй байна. (банк М. , Төсөвчин аппликейшн, 2017)
- Мөн 2016 оноос Дэлхийн банкны зөвлөмжийн дагуу хоёр үе шаттайгаар “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.
- Түүнчлэн 2021 оны 3-р сарын 22-оос 4-р сарын 12ныг хүртэл OECD/INFE хэрэгжүүлж буй “Дэлхийн мөнгөний долоо хоног”-ийг амжилттай зохион байгуулсан байна.

2. Голомт банк

- “Finedu” бол “Голомт банк”-ны платформ бөгөөд иргэд, бизнес эрхлэгч, оюутан сурагч гээд хэн бүхэнд банк санхүү, эдийн засгийн анхан шатны цогц ойлголтыг энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарласан мэдээллийн сан юм. (Голомт, 2021)

3. Хас банк

- Хас банк нь 2017 онд Global Money week хөдөлгөөний хүрээнд санхүүгийн мэдлэг боловсрол олгох сургалтыг ахлах ангийн 1100 сурагчид зохион явуулж тэдгээр хүүхдүүдэд ХасБанкны ТУЗ-ийн гишүүдийн дэмжлэгтэйгээр Ирээдүйн саятан хадгаламж нээж өгөх зэрэг олон ажлыг зохион байгуулсан байдаг. (банк Х. , 2017)

1.4 Олон улсын санхүүгийн боловсрол олгох байгууллагууд болон тэдгээрийн хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

Олон улсад (European investment bank/Institute, OECD/INFE, NEFE) гэх зэрэг санхүүгийн боловсрол олгох олон байгууллагууд байдаг. Эдгээрээс 2020 онд Knology болон NEFE нар хамтран санхүүгийн боловсролд зориулан хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын үр нөлөөний талаархи судалгаа явуулсан байдаг. Тухайн судалгааны үр дүнд нэг оюутанд ногдох санхүүгийн боловсролд зарцуулах зардал нэмэгдсэнээр санхүүгийн боловсролын түвшин нэмэгдэж байна гэж үзжээ. Үүний шалтгаан нь мэдээлэл хүргэх сувгуудыг олон болгох буюу санхүүгийн боловсролын бүтээгдэхүүнүүдийг тоог нэмэгдүүлснээр оюутнуудын санхүүгийн боловсрол нэмэгдсэн аж. Үүнээс үүдэн санхүүгийн боловсролд зориулах зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай гэсэн үр дүнд хүрсэн байна. (site, 2020)

Итали улсад 2016 онд MOLE (Money Learning) төсөл хэрэгжин Fondazione per la Scuola (Compagnia di Sanpaolo) European investment bank-тай хамтран санхүүгийн боловсрол олгох ажлыг бага сургуулийн (8-10 насны) хүүхдүүдийн дунд зохион байгуулсан. Мөн хувийн санхүүгийн менежмент, санхүүгийн боловсролд зориулагдсан анхны мультимедиа, интерактив музейд оюутнуудыг үнэгүй аялуулах үйл ажиллагаа зохион байгуулсан. (Rispparmio, n.d.)

Болгар улсад 2014-2018 оны хооронд 15-18 насны 2500 орчим Болгар оюутнууд хүрээлэнгийн Афлатун Интернэшнлтэй хамтран ажилласан нь үр нөлөөтэй байлаа. Амстердамд төвтэй энэхүү ТББ нь түншүүдийнхээ сүлжээгээр дамжуулан хүүхэд, залуучууд, ялангуяа эмзэг бүлгийнхэнд нийгмийн болон санхүүгийн боловсрол олгосон байна. (Rispparmio, n.d.)

Явцын дүгнэлт

Санхүүгийн боловсролыг маш энгийнээр тодорхойлбол хязгаарлагдмал нөөцийг үр ашигтай хувиарлах явдал бөгөөд зөвхөн хувь хүнд бус тухайн улс орны эдийн засгийн үзүүлэлттэй салшгүй холбоотой байдгын хувьд орхигдуулж болшгүй чухал үзүүлэлт юм. Бид санхүүгийн боловсролыг эзэмшсэнээр мөнгөө хэрхэн удирдах, бидэнд үйлчилдэг санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа хэрхэн явагддаг, санхүүгийн бүтээгдэхүүнийг хэрхэн зөв зохистой ашиглах зэрэгт суралцаж мөнгөнд удирдуулах биш мөнгийг удирдах чадвартай болох юм. Тиймээс дэлхийн улс орнууд иргэдийнхээ санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлд олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсээр байгаа билээ. Үүний адилаар манай улс ч гэсэн санхүүгийн боловсрол олгох чиглэлээр төсөвчин аппликейшн, арилжааны

банкуудаас гаргасан платформ, “мөнгөний долоо хоног” аян зэрэг ажилуудыг зохион хэрэгжүүлсээр байна.

Өнөөгийн байдал

2.1 Монгол улсын санхүүгийн боловсролын өнөөгийн байдал

Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд санхүүгийн боловсрол хэмээх ойлголт эрчимтэй судлагдаж эхлээд байна. Санхүүгийн боловсролын түвшний судалгааг ихэвчлэн олон улсын донор байгууллагууд санхүүжүүлж хийсэн байдаг. МУ-ын хувьд хүн амынхаа санхүүгийн боловсролоороо дэлхийн хэмжээнд хэдэд эрэмбэлэгдэж байгааг судлан тодорхойлоогүй ч энэ чиглэлийн албан болон албан бус хөтөлбөрүүд хэрэгжсээр байна. СЯ-ны хүсэлтийн дагуу Дэлхийн Банкаас МУ-ыг хамарсан санхүүгийн чадавхын судалгааг 2012 онд явуулсан. Судалгааны хүрээнд санхүүгийн боловсролын цогц стратеги хэрэгжүүлэх шаардлагатай гэж дүгнэсэн. Үүний дагуу “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 оны 10 дугаар сарын 02-ноос 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд Монгол банк “Санхүүгийн боловсрол” аяныг санаачлан хэрэгжүүлсэк, (Монгол)

Уг аяны хүрээнд Монголбанк, СЯ, СЗХ, БСШУЯ (хуучин нэрээр) хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг боловсруулан баталж, 2 үе шаттайгаар, дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох;
2. Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
3. Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
4. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг

Одоогоор энэхүү хөтөлбөр нь 2-р үе шатандаа явж байна. Мөн АХБ-ны Ядуурлыг бууруулах Японы сангийн (ЯБЯС) санхүүжилтээр 2012 оноос СЗХ, МХСМТ, МҮХЗХХ-той хамтран “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл” (ЯИЧСҮХНТ)-ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ төслийн “Б” бүрэлдэхүүн хэсэг нь бага

дунд орлоготой иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үндсэн чиглэл тусгагдан, хэрэгжүүлэх маркетингийн төлөвлөгөө боловсруулсан ажилласан байдаг. (хороо, 2013)

2.2 Олон улс дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал

Энэ судалгаа нь насанд хүрэгчдийн санхүүгийн боловсролыг сорих ерөнхий 7 асуултуудаас бүрдэнэ. Зөв хариулт өгөхийн тулд санхүүгийн анхан шатны мэдлэг болох инфляци, энгийн ба хуримтлагдсан хүү ба эрсдэл гэх мэтийн суурь мэдэгдэхүүнтэй байх хэрэгтэй. OECD (Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага)-д бүртгэлтэй улс орны насанд хүрэгчдийн 87,5%, болон нийт насанд хүрэгчдийн 84,4% нь зээлийн энгийн хүүгийн талаарх асуултанд зөв хариулж чаджээ. Нийт судалгаанд хамрагсадын гуравны нэг болох OECD-д бүртгэлтэй улсын гишүүдийн 28,8% нь энгийн болон нийлмэл хүүний талаарх мэдлэгтэй байсан. Харин бараг 80% нь инфляцийн талаарх тодорхойлолт, ойлголттой байсан. Эрсдэлийн тухайд 2 агуулга бүхий асуулттай бөгөөд эхний асуулт нь эрсдэл ба өгөөжийн хоорондох уялдаа холбооны талаар, хоёр дах асуулт нь эрсдэл болон эрсдэлээс хамгаалах арга гэх агуулгаас бүрдсэн. Эхний асуултад 77% нь амжилттай, зөвөөр хариулсан бол 58,9% нь эрсдэл болон диверсификацийн талаар зөв хариулт өгсөн үзүүлэлттэй байна. Насанд хүрсэн иргэдээс авсан асуултуудад хамгийн өндөр үзүүлэлт бий болгосон улс Австри байсан бол 2 дугаар байранд Булгар, удаах байранд Колумб улс орсон байна.

Нийт 26 улс орноос, 12 нь OECD-д бүртгэлтэй улс байсан бөгөөд 26 улс орны дундаж үзүүлэлт нь 52,5% байсан нь олон улсад санхүүгийн боловсрол анхан шатны мэдлэгийн хүрээнд байгааг харуулсан.

2.3 Монгол улсын их, дээд сургууль дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал:

Монгол улсын санхүүгийн байгууллагын 97%-ийг банкны үйлчилгээ эзэлдэг ба иргэдийн ихэнх хувь нь банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг ашигладаг байна. Иймд банкны салбарын ажилтнуудад иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх тухай сургалт, үйл ажиллагааг нэн түрүүнд явуулах хэрэгтэй. Мөн их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт “Хувь хүний санхүүгийн боловсрол” хичээлийг мэргэжил хамааралгүй оруулан санхүүгийн боловсролтой болгох нь зөв. Үүнээс өмнө оюутан залуучуудын санхүүгийн боловсролын түвшнийг тодорхойлох хэрэгтэй гэжээ. (Энхболд, 2016)

Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 18-25 насны залуучуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор санхүүгийн мэргэжлийн бус хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад их дээд сургууль болон МСҮТ-ийн сургалтын төлөвлөгөөнд “Хувь хүний санхүү” хичээлийг оруулах замаар энэхүү хичээлийг заах нөхцөлийг бүрдүүлсэн. Энэ ажиллагааны хүрээнд МУИС-ийн БС, СЭЗИС, ХААИС-ийн багш нарын бүрэлдэхүүнтэй баг оюутан залууст санхүүгийн мэдлэг олгох “Хувь хүний санхүү” хичээлийн хөтөлбөр, сурах бичиг, дасгал ажлын номыг боловсруулан, Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд хэвлүүлж оюутан залуусын хүртээл болгосон. Мөн 2017 онд уг хичээлийг заах сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг зохион байгуулж, их, дээд сургуулийн нийт 48 багш хамрагдаж, гэрчилгээ гардан авчээ. (банк М. , Монгол банк, 2019)

Эдгээр бэлтгэл ажиллагааны үр дүнд “Хувь хүний санхүү” хичээлийг нийт 14 их дээд сургууль сургалтын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхээр Монгол банкинд хүсэлтээ ирүүлжээ. Энэхүү сургуулиудыг Олон улсын их дээд сургуулиудын зэрэглэлийг гаргадаг UNIRANK сайтаас гаргасан Монголын их дээд сургуулиудад өгсөн зэрэглэлээр жагсаавал: [UniRank, 2021]

№	Сургуулийн нэр	Дэлхийд (байр)	Монголд(байр)
1	МУИС	5102	1
2	ШУТИС	6595	2
3	МУБИС	8774	4
4	ХААИС	9844	6
5	СЭЗИС	10285	7
6	ЭТҮГЭН	10691	11
7	Олон улсын Улаанбаатар их сургууль	11486	15

8	Улаанбаатар эрдэм их сургууль	12017	21
9	Сан дээд сургууль	12314	25
10	Дорнод их сургууль	12619	37
11	Олон улсын эдийн засаг бизнесийн дээд сургууль	12847	40
12	Эдийн засгийн үндэсний дээд сургууль	12896	41
13	Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль	Энэ судалгаанд оруулаагүй байсан	
14	Хууль сахиулахын их сургууль	Энэ судалгаанд оруулаагүй байсан	

Эдгээрээс 10 их, дээд сургууль сургалтын төлөвлөгөөндөө “Хувь хүний санхүү” хичээлийг оруулсан, үүнээс Хууль сахиулахын их сургууль өөр хичээлийн агуулгад багтаасан байна. Харин 2 сургуулийн оюутнууд энэ хичээлийг сонгоогүй бөгөөд 1 сургууль оюутан сонгохгүй байгаа шалтгаанаар сургалтын төлөвлөгөөнөөс хасжээ. Энэ нь санхүүгийн мэргэжлийн ангийн сургалтын төлөвлөгөөнд “Хувь хүний санхүү” хичээлийг оруулсантай холбоотой юм. Учир нь мэргэжлийн ангийн оюутнууд санхүүгийн хичээлийг мэргэжлийн боловсролын түвшинд судалдаг тул “Хувь хүний санхүү” хичээлийг сонгон судлах хэрэгцээ, шаардлага бага юм. (банк М. , Монгол банк, 2019)

Уг хичээлийн хүрээнд нийт 16 сэдвээр оюутан залууст санхүүгийн мэдлэг олгож байна. Энэхүү хичээлийн үр дүнгийн талаар 2019 онд хийсэн судалгаанд нийт 341 оюутан хамрагдсан бөгөөд сургуулиар нь авч үзвэл МУИС – 41.5 хувь, СЭЗИС – 11.5 хувь, ХҮИС – 45.2 хувь хамрагдсан бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлсэн сургуулиудыг хангалттай төлөөлөж чадна гэж үзсэн. Судалгаанд оролцогчдын хамгийн бага нь 17 настай, хамгийн их нь 23 настай, харин хүйсийн хувьд 28.8 хувь нь эрэгтэй, 71.2 хувь нь эмэгтэй байв. Сурч буй мэргэжлээр нь нарийвчлан харахад 22.2 хувь нь санхүүгийн, 20.7 хувь нь нягтлан бодох бүртгэлийн, 10.7 хувь нь банкны, 46.4 хувь нь бусад мэргэжлээр суралцаж буй оюутнууд байжээ. (банк М. , Монгол банк, 2019)

“Хувь хүний санхүү” ном нь дараах агуулгатай байдаг ба эдгээр сэдвийг судласны үр дүнд оюутнуудад гарсан өөрчлөлтийг судалгааны үр дүнгээр оруулсан болно. (банк М. , Монгол банк, 2019)

- **Бүлэг 1. Хувийн санхүүгийн тухай ойлголт**

1. Хувь хүний санхүүгийн мөн чанар, зорилго, үүрэг, зарчим, ач холбогдлын талаар мэдлэгтэй болсон – 53.7 хувь;
2. Санхүүгийн төлөвлөгөө, шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг ойлгож, оновчтой шийдвэр гаргах чадвартай болсон – 46.3 хувь.
3. Хувийн санхүүгийн төлөвлөлт хийх чадвар эзэмшсэн – 36.3 хувь;
4. Хувь хүний санхүүгийн шийдвэртэй холбоотой алдагдсан боломжийн өртөгийг тодорхойлох чадвартай болсон – 30 хувь;
5. Амьдралын нөхцөл байдалд тохируулан санхүүгийн зорилгоо тодорхойлж чаддаг болсон – 33.7 хувь.
6. Ажил мэргэжлийн сонголт, төлөвлөлт, шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг ойлгож мэдсэн – 50 хувь;
7. Ажил мэргэжлээ оновчтой төлөвлөж, оновчтой шийдвэр гаргах чадвар эзэмшсэн – 50 хувь.

- **Бүлэг 2. Мөнгө, мөнгөний үнэ цэнэ**

1. Инфляцийн үзүүлэх нөлөө, хүү, түүний тооцоолол, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн талаар ойлголттой болсон – 50.5 хувь;
2. Уг мэдлэгийг санхүүгийн шийдвэр гаргахдаа ашиглах чадвартай болсон – 49.5 хувь.
3. Төсөв, түүний бүтцийн талаар онолын мэдлэгтэй болсон – 32.6 хувь;
4. Хувь хүний болон өрхийн төсөв, түүнийг удирдах арга барилд суралцсан – 38.3 хувь;
5. Өрхийн төсвөө төлөвлөх, шинжилгээ хийх, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх мэдлэг чадвартай болсон – 29.1 хувь.
6. Хувийн татварын төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгосон – 32.6 хувь;
7. Татварын талаар онолын мэдлэгтэй болсон – 38.3 хувь;

8. Татвар ногдох орлого болон ногдуулах орлого, татварын өглөгийг тооцоолох, татварын тайлан гаргах чадвар эзэмшсэн – 29.1 хувь

● **Бүлэг 3. Хувийн санхүүгийн шийдвэр гаргалт**

1. Санхүүгийн зах зээлийн талаар ойлголт, мэдлэгтэй болсон – 52.6 хувь;

2. Санхүүгийн зах зээл, санхүүгийн зуучлагч байгууллагуудын тусламжтайгаар хувийн болон өрхийн санхүүгээ удирдах чадвар эзэмшсэн – 47.4 хувь.

3. Зээл, түүний мөн чанарыг мэддэг болсон – 52.6 хувь;

4. Зээлийн ангилал, зарчим, нөхцөлүүдийг ойлгон, зээлийн шийдвэр гаргахдаа хэрэглэх чадвар эзэмшсэн – 47.4 хувь.

5. Зээлийн эрсдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар ойлголттой болсон – 48.4 хувь;

6. Зээлийн эрсдэлээс сэргийлэх арга замын талаар онолын мэдлэгтэй болсон – 51.6 хувь.

● **Бүлэг 4. Хувийн санхүүгийн шийдвэр гаргалт**

1. Хуримтлал, хадгаламж, тэдгээрийн төрөл, онцлог, хадгаламжийн орлогын тооцооллын талаар онолын мэдлэгтэй болсон – 48.4 хувь;

2. Хадгаламжийн оновчтой шийдвэр гаргах чадвар эзэмшсэн – 51.6 хувь

3. Хувьцаа, бонд болон хөрөнгө оруулалтын бусад хувилбаруудын онцлог, ялгаа, төрөл, ач холбогдлын талаар онолын мэдлэгтэй болсон – 45 хувь;

4. Хувийн мөнгөн хөрөнгөө оновчтой удирдаж, өөрийн санхүүгийн зорилго, нөхцөл байдалд тохируулан хөрөнгө оруулалтын хувилбаруудаас оновчтой сонголт хийх чадвар эзэмшсэн – 36.1 хувь;

5. Хувийн хуримтлалаа өсгөх, орлого ашиг олохтой холбоотой оновчтой шийдвэр гаргах чадварт суралцсан – 28.9 хувь.

● **Бүлэг 5. Тэтгэврийн ба өв хөрөнгийн төлөвлөлт**

1. Даатгал, даатгалын хамгаалалтын талаар онолын мэдлэгтэй болсон – 54.6 хувь;

2. Арилжааны даатгалд хамрагдахын ач холбогдлыг ойлгосон – 45.4 хувь.

3. Өв хөрөнгийн төлөвлөлт хийх, гэрээслэл, итгэмжлэлийн талаар онолын мэдлэгтэй болсон – 35.4;

4. Өв хөрөнгөө төлөвлөх, гэрээслэл бичих чадвар эзэмшсэн – 31.5 хувь;

5. Өв хөрөнгийн төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгосон – 33.1 хувь.
6. Өв хөрөнгийн төлөвлөлт хийх, гэрээслэл, итгэмжлэлийн талаар онолын мэдлэгтэй болсон – 35.4;
7. Өв хөрөнгөө төлөвлөх, гэрээслэл бичих чадвар эзэмшсэн – 31.5 хувь;
8. Өв хөрөнгийн төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгосон – 33.1 хувь.

Судалгаанд хамрагдсан оролцогчдын 87.3 хувь хөтөлбөрийн чанар, хүртээмжийг дээшлүүлэх талаар ямар нэгэн санал байхгүй хэмээн хариулсан нь энэ талын ойлголт мэдлэг дутмаг, хангалтгүй байгаатай холбоотой гэж судлаачдын зүгээс үзсэн байна. (банк М. , Монгол банк, 2019)

Олон улсын хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсрол байгууллагаас 2011 оноос эхлэн Дэлхийн 170 орны 24000 гаруй байгууллагыг нэгтгэн хүүхэд, залуучуудын санхүүгийн боловсрол, санхүүгийн хүртээмж болон санхүүгийн бодлогын чиглэлээр хамтран ажиллаж ирсэн. Дээрх ажлын хүрээнд 2012 оноос эхлэн улс орнуудын хүчин чармайлтыг үнэлэн “Олон улсын хүртээмж” шагналд тодорхойлох болсон. Үүнээс манай улс

- “Ази & Номхон далайн бүсийн санхүүгийн хүртээмжтэй байдал” шагналыг 2016 онд
- “Шилдэг түншлэл улс-2019” шагналыг тус тус хүртжээ. (Хүүхдийн эрх | UNICEF Монгол, 2019)


2.4 Олон улсын их дээд сургууль дахь санхүүгийн боловсролын өнөөгийн байдал

Залуучуудын хувьд коллежийн боловсролоо хэрхэн санхүүжүүлэх талаар шийдвэр гаргахдаа санхүүгийн зах зээл дээр туршлага багатай байдаг нь санаа зовох шалтгаан болж байдаг. Учир нь оюутнууд хичээлээр онолын ойлголтыг их авдагч ч практикт хэрэгжүүлдэггүй учраас аливаа шийдвэр гаргалтад туршлага дутмаг байдал ажиглагддаг.

2015 оны Олон улсын оюутны үнэлгээний хөтөлбөрийн хүрээнд явуулсан санхүүгийн мэдлэгийг үнэлэх шалгалтын үр дүнгээс харахад АНУ дахь 15 насны хүүхдүүдийн дөнгөж 29 хувь нь өөр өөр хүүтэй, хугацаатай зээлийг харьцуулж чаддаг болохыг судалсан байна. (National Center for Education Statistics (NCES), 2017)

Дэлхийн эдийн засгийн форум (The World Economic Forum) “Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан”-д боловсролын чанараар тэргүүлэх улс орнуудыг жагсаасан байдаг. Тус жагсаалтад багтсан зарим улс орнуудын нэг багшид ногдох суралцагчдын тоог харьцуулан дараах зурагт харуулав. Нэг багшид ногдох суралцагчдын тоогоор хамгийн бага нь Норвеги улс (9.6), хамгийн их нь Колумби улс (30.7) байна. Харин Монгол Улсад нэг багшид 22.7 оюутан ногдож байна.

Нэг багшид ногдох суралцагчид, улсаар



25-64 насны хүн амд 6 дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй тухайн насны суралцагчдын эзлэх хувийг 2017 оны байдлаар авч үзвэл, АНУ 46.4 хувь, Их Британи болон Ирланд 45.7 хувь, Финланд 44.3 хувь байгаа нь хамгийн өндөр байна. Харин Монгол Улсад дээрх улсуудтай харьцуулахад бага буюу 25-64 насны нийт хүн амын 9.7 хувь нь дээд боловсрол эзэмшихээр суралцаж байна.

2.5 Олон улсын их дээд сургуулиудын санхүүгийн боловсролд хийсэн үнэлгээ

1. Франц улс

- 2020 онд хийсэн “Санхүүгийн боловсрол нь нийгэм-хүн ам зүйн шинж чанар, зан төлөвд үзүүлэх үр нөлөөг үнэлэх” гэсэн судалгаанд дурдсанаар коллежид элсэж буй оюутнууд санхүүгийн туршлага бага байдаг ч зээлийн талаар нарийн төвөгтэй шийдвэр гаргадаг байна. Энэхүү судалгаа нь эдгээр

шийдвэрийг сайжруулж болох бодлогын хөшүүргийг авч үзэн судалсан байдаг.

- Энэхүү судалгаа нь санхүүгийн мэдлэгийг өрхийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх чухал хүчин зүйл гэж үзэх ёстойг нотолж харуулсан байна. Мөн Засгийн газар болон санхүүгийн байгууллагуудыг санхүүгийн боловсролын үндэсний хөтөлбөрийг бий болгохыг уриалж байжээ. [Mouna Amari, 2020]

Малайз улс

- Энэхүү судалгаа нь санхүүгийн боловсрол, санхүүгийн хандлага, эцэг эхийн санхүүгийн нийгэмшлийг зохицуулагч болох үүргийг судлах зорилготой 2020 онд хийгдсэн байна.
- Үр дүн нь залуучуудын санхүүгийн асуудлаа ухаалгаар удирдах чадварыг дээшлүүлэхэд Санхүүгийн боловсролийн нь үр нөлөөг ноцтой анхаарал хандуулж байх хэрэгтэй нь харагдсан байна. (Mohd Zamri, 2020)

2. Зүүн Анатолийн их сургууль

- Санхүүгийн боловсролд нөлөөлөгч хүчин зүйлийг тодорхойлох судалгаа юм. Санхүүгийн боловсрол нь санхүүгийн хөгжил, тогтворжилт, эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйл юм. Энэхүү судалгаагаар Ататүркийн их сургуулийн албан болон дунд боловсролын бакалаврын түвшний оюутнуудын санхүүгийн мэдлэгийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлсон байна. Энэхүү судалгааны загварын үр дүнгээс харахад нас, анги, шинжлэх ухааны суурь салбар, хүйс, гэрлэлтийн байдал, сарын хувийн орлого, эко санхүүгийн мэдээний байдал, эдийн засгийн мэдлэгийн хувьсагчид санхүүгийн мэдлэгийн түвшинд нөлөөлсөн хүчин зүйл болох нь тогтоогдов. Судалгаанаас харахад 25-аас доош насны эмэгтэйчүүд, шинжлэх ухааны чиглэлээр их дээд сургуулийн оюутнууд, дөрөв дэх жилээс дээш насны, сарын хувийн орлого 12500 ба түүнээс доош хувийн, ганц бие, эдийн засгийн болон санхүүгийн мэдээ, эдийн засгийн мэдлэг багатай байсан. Эдгээр бүлгүүдийн санхүүгийн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай байна. [Ömer Alkan, 2020]

3. Индонез

- Энэхүү судалгаагаар Индонезийн Палембанг хотод үйл ажиллагаа явуулдаг төрийн болон хувийн их дээд сургуулийн оюутнуудын санхүүгийн мэдлэгийн түвшинг онлайн асуулга тарааж хэмжжээ. Санхүүгийн мэдлэгийн талаархи асуултууд нь тоон үзүүлэлт ба нийлмэл хүү, инфляци, эрсдлийн төрөлжилт гэсэн гурван сэдвийг хамарсан Standard & Poor's Rating Services-т хамаарна. Энэ зорилгоор (Eviews) ашиглан санхүүгийн мэдлэгийн түвшинг явуулсан. Үр дүнгээс харахад улсын их дээд сургуулиудын нийт оролцогчдын 12% нь бүх асуултанд зөв хариулсан байгаа нь хувийн их сургуулийн оюутнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тооны болон нийлмэл хүүгийн талаарх асуулгыг өрнүүлсэн байна. Нөгөөтэйгүүр, эрсдэлийг төрөлжүүлэхтэй холбоотой зөв хариулсан хувь нь ердоо 27% байна. Санхүүгийн бичиг үсэг тайлагдаагүйн үр дагавар нь ирээдүйн санхүүжилтэд нөлөөлж болзошгүй санхүүгийн шийдвэрүүд юм. (Setiawan, 2020)

4. Турк улс

- Энэхүү судалгаанд Туркийн Анадоу их сургуулийн нээлттэй боловсролын системд хамрагдсан оюутнуудын санхүүгийн мэдлэгийг судласан байна. Шинжилгээ хийсний үр дүнд дараахь дүгнэлтийг хийсэн бөгөөд үүнд:
- Оюутнуудын 70% нь санхүүгийн мэдлэгийн түвшинг хэмжих асуултанд зөв хариулсан байна.
- Мөнгөтэй холбоотой асуултуудад тодорхойлсон хүчин зүйлсийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд зарим ялгаа байдаг.
- Зээлийн карт нь оюутнуудын дунд алдартай байдаг.
- Хүйс ба ажил эрхлэлтийн хооронд статистикийн ач холбогдолтой хамаарал байна.
- Санхүүгийн хөрөнгийг сонгоход хамгийн чухал мэдээллийн эх үүсвэрүүд нь интернет, банкны салбар, хувийн мэдлэг, хөрөнгийн маркетингийн мэргэжилтэн, интернет юм.
- Мөнгөтэй холбоотой асуултуудаас хамгийн өндөр дэмжлэг нь "Аливаа худалдан авалт хийхээсээ өмнө санхүүгийн байдлаа шалгаж, энэ худалдан авалтыг хийж чадаж байгаа эсэхээ шалгадаг" гэсэн асуулт гарч ирдэг бөгөөд

энэхүү судалгаанаас харахад нээлттэй боловсролын факультет оюутнууд санхүүгийн хөрөнгийг мэддэг. [Fikret Er, 2017]

Дэлхийн их сургуулиудын хэрэглэдэг санхүүгийн боловсролын тухай ном сурах бичиг болон тэдгээр сургуулиудын үнэлгээнүүд

Номын нэр	Зохиогчийн нэр	Сургуулийн нэр	Ранк	Товч тайлбар
The Undercover Economist	Tim Harford (Little, Brown, 2005)	University of Oxford	1	"Эдийн засаг гэдэг нь ДНБ гэх мэт нэртэй нэлээд бүдэг статистик биш" "Эдийн засаг гэдэг нь хэн юуг, яагаад авахыг л хэлдэг." гэж гэж "NPR's Marketplace" -ийн тоймч, тоймч Тим Харфорд хэлсэн байдаг. Номын нэг хэсэгт дэлхийн мөнгө хэрхэн ажилладаг арга хэлбэрийг тодорхойлсон байдаг.
Macroeconomics	Charles I. Jones W.W. Norton & Co New York 2020	Stanford University	2	Макро эдийн засаг бол нэг үеийн хамгийн сонирхолтой шинэ эдийн засгийн сурах бичиг юм. Чарльз Жонс орчин үеийн макро эдийн засгийг хэрэгжүүлж байгаа тул орчин үеийн өсөлтийн онолыг хамарсан анхны текстийг гаргалаа. Багш, зохиолчийн чадвар нь энэ салбарт шинээр

				суралцаж буй оюутнуудад хялбар унших боломжийг олгодог
Finance for Managers	Harvard Business School Press, Paperback: 256 pages	Harvard Business School	3	Бизнесийн санхүүгийн ерөнхий байдлыг тооцоолох, үнэлэх нь аливаа удирдах албан тушаалын чухал хэсэг юм. Санхүүгийн тайланг унших, тайлах, өнөөгийн цэвэр үнэ цэнийг ойлгох, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолохоос эхлээд энэ ном нь санхүүгийн мэдлэгийн үндсийг агуулсан болно. Ашиглахад хялбар бөгөөд техникийн бус энэхүү гарын авлага нь менежерүүдэд санхүүгийн төлөвлөлт, төсөвлөлт, урьдчилсан тооцоонд үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэхэд шаардлагатай ухаалаг зөвлөгөөг өгдөг.
Financial Business Analysis and Valuation	Krishna G. Palepu, Paul M. Healy, Victor L. Bernard	South-Western College	205	Санхүүгийн тайлан нь бизнесийн өргөн хүрээний дүн шинжилгээ хийх үндэс суурь болдог. Менежерүүд, үнэт цаасны шинжээчид, банкирууд, зөвлөхүүд бүгд бизнесийн шийдвэр гаргахад ашигладаг. Бизнесийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд

				санхүүгийн тайлангийн мэдээллийг бизнесийн олон янзын дүн шинжилгээ, үнэлгээний нөхцөл байдалд ашиглах орчин нөхцлийг бүрдүүлдэг сургалтын материал эрэлт ихтэй байдаг
--	--	--	--	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Өнөөгийн байдлын дүгнэлт

Монгол улсын хувьд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 оны 10 дугаар сарын 02-ноос 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд Монгол банк “Санхүүгийн боловсрол” аяныг санаачлан хэрэгжүүлсэн бөгөөд одоогоор хоёрдугаар үе шатандаа, тэргүүлэх чиглэлийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Харин олон улсад судалгаа хийсэн OECD байгууллагын үр дүнд санхүүгийн мэдлэгээрээ Австри тэргүүлж байсан бол 2 дугаар байранд Булгар, удаах байранд Колумб улс орсон байна. Олон улсад иргэдийнхээ санхүүгийн боловсролын хүртээмжийг сайжруулахын тулд олон төрлийн судалгаа авч, түүний үр дүнд тохирсон зөв шийдэл бүхий гарц болгож, их сургуулиудын хичээлийн хөтөлбөрт стандарт хангасан ном сурах бичиг хэрэглэн, цаашдын үр нөлөөг дэмжиж байна. Тэгвэл монгол улсад иргэдийн санхүүгийн боловсролын түвшинг тогтоосон судалгаа тоотой хэд байдаг тул тэднийг шинжлэн, зөвхөн хичээлийн агуулгын хүрээнд бус, олон нийтэд хүртээлтэй байхаар шинэлэг арга замыг хайж, олох хэрэгтэй байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Статистикийн тоон мэдээлэл болон баримт ашиглан иш татахдаа олон улсын байгууллагуудын бодлого журам, зөвлөмж болон судалгаануудыг ашигласан.

Асуудал	Нийт оюутнуудын санхүүгийн боловсролын түвшинг дээшлүүлэх арга зам, түүнд нөлөөлөх хүчин зүйлс.
Таамаглал	Оюутнуудын мэргэжил, нас, сургууль гэх мэт ялгаатай зүйлс санхүүгийн боловсролд нөлөө үзүүлдэг. Мөн хамгийн чухал зүйл бол мэдээллийн хэрэгслээ авах суваг юм.

Зорилго	Санхүүгийн боловсролын өнөөгийн байдлыг үнэлэх
Онолын тойм	Санхүүгийн боловсролыг дэлгэрэнгүй судалсан
Судалгааны арга зүй	Бакалаврын түвшний оюутнууд болон олон нийтийн санхүүгийн байдлыг үнэлэх,
Судалгааны хязгаарлалт	Их сургуулийн оюутнууд

4.1 Их дээд сургуулийн оюутнуудын дунд хийсэн судалгаа

“Бакалаврын түвшний оюутнууд” болон “Олон нийтийн” хувь хүний санхүүгийн тухай ойлголт, хандлага, тэдгээрийн уялдаа холбоог судлах зорилгоор нийт 400 хүнээс 100% онлайн хэлбэрээр судалгаа авч боловсруулсан болно.

Бакалаврын түвшний оюутнуудын хувийн санхүүгийн судалгаанд нийт 250 оюутан оролцсон байна.

Бидний судалгаагаар нь үндсэн 6 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Хувь хүний санхүүгийн боловсрол
- Зээл ба хадгаламж
- Даатгал
- Хөрөнгө оруулалт
- Хувийн санхүүгийн боловсролын үнэлгээ ба шийдвэр
- Хувь хүний мэдээлэл

Санхүүгийн боловсрол

4.2 Их дээд сургуулиудын багш судлаач нарт хийсэн судалгааны үр дүн

Манай судалгаанд оролцогсдын 45.2% нь урьд өмнө нь санхүүгийн боловсрол олгох сургалтанд хамрагдаж байсан ба дийлэнх буюу 89.2% нь санхүүгийн мэдээлэл мэдлэгийн хэрэгцээ шаардлагатай гэж үзсэн бөгөөд хэрвээ энэ талаар сургалт хөтөлбөр зохиовол 84% нь хамрагдах хүсэлтэй гэсэн хариу гарсан байна. Үүнээс харахад оюутнууд санхүүгийн талаарх мэдлэгийн эрэлт өндөр байгаа нь харагдаж байна. Онолын мэдлэг шалгах асуултнаас оюутнууд 64% орчим хувьтай асуултанд зөв хариулж чадсан бол даатгал сэдвийн хүрээнд харьцангуй муу хийсэн байна.

Descriptive Statistics

	N	Range	Minimum	Maximum	Mean		Std.Deviation	Variance	Skewness		Kurtosis	
	Statistic	Statistic	Statistic	Statistic	Statistic	Std.Error	Statistic	Statistic	Statistic	Std.Error	Statistic	Std.error
Та санхүүгийн боловсролын тухай мэдээллийг ихэвчлэн хаанаас авдаг вэ?	250	8.0	1.0	9.0	3.092	0.1501	2.3736	5.634	1.058	0.154	0.2	0.307
Энэ төрлийн сургалт хөтөлбөр нь хэрхэн үр дүнтэй байх вэ?	250	60	1.0	7.0	7.0	3.476	1.9226	3.696	0.298	0.154	-0.796	0.307
Зээлийн картны талаарх мэдээллээс аль нь худлаа вэ?	250	4.0	1.0	5.0	2.604	0.0861	1.3618	1.855	0.486	0.154	-0.998	0.307
Нэмэгдүүлсэн хүү гэж аль нь вэ?	250	4.0	1.0	5.0	2.436	0.0648	1.0247	1.050	1.122	0.154	0.581	0.307
Зээлийн төрөлд аль нь хамаарахгүй вэ?	250	4.0	1.0	5.0	4.524	0.0629	0.9947	0.989	-2.214	-0.154	3.917	0.307
Үндсэн зээл гэж дараахаас алийг нь хэлэх вэ?	250	4.0	1.0	5.0	2.040	0.0658	1.0405	1.083	0.847	0.154	-0.083	0.307
Valid N (listwise)	250											

Ерөнхий тоон утгууд

Статистик ерөнхий мэдээлэл	Насны ангилал	Хүйс	Курс	Сургууль	Мэргэжил
Товч тайлбар	31.6%, 27.2%-иар 19, 20 настай оюутнууд зонхилсон	70:30 Ихэвчлэн эмэгтэй хүмүүс хамрагдсан	30.8%-иар 2-р курсийн оюутнууд зонхилж бүрдүүлсэн	54.4% нь СЭЗИС-ийн суралцагсад байна. Үүний дараа МУИС 18% -аар бүрдүүлсэн	Түүврийн хамгийн их буюу 20%- ийг нягтлан бодох бүртгэлээр сурдаг оюутнууд

					бүрдүүлсэн байна.
Түүврийн дундаж	2.708	2.308	3.812	1.700	5.092
Түүврийн таллан хуваасан утга	3	2	1	2	5
Стандарт хазайлт	1.2381	1.1036	4.9828	0.4763	2.3361
Скюнес	0.52 баруун өрөөсгөлтэй	0.786 баруун өрөөсгөлтэй	1.66 баруун өрөөсгөлтэй	-0.652 Зүүн өрөөсгөлтэй	-0.154 Зүүн өрөөсгөлтэй
Ранжэ	5.00	4.00	14.00	2.00	7.00
Түүврийн хамгийн их утга	6.00	5.00	15.00	3.00	8.00
Түүврийн хамгийн бага утга	1.00	1.00	1.00	1.00	1.00

Регрессийн шинжилгээ

Санхүүгийн төлөвлөгөө гаргадаг хугацаа нь тухайн оюутны мэргэжил, курсд хамааралтай эсэхийг шалгахын тулд тухайн 3 хэмжигдэхүүнийг сонгон авч корреляц хийж үзлээ.

	Mean	Std. Deviation	N
24. Та санхүүгийн төлөвлөгөөгөө ямар хугацаанд гаргадаг вэ?	1.340	0.5812	250
Та хэддүгээр курсын оюутан бэ?	2.308	1.1036	250
	5.092	2.3361	250

30.Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?			
--------------------------------------------	--	--	--

Correlations				
		24. Та санхүүгийн төлөвлөгөөгөө ө ямар хугацаанд гаргадаг вэ?	30. Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?	26. Та хэддүгээр курсын оюутан бэ?
Pearson Correlation	24. Та санхүүгийн төлөвлөгөөгөө ямар хугацаанд гаргадаг вэ?	1.000	.148	-.014
	30. Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?	.148	1.000	-.009
	26. Та хэддүгээр курсын оюутан бэ?	-.014	-.009	1.000
Sig. (1-tailed)	24. Та санхүүгийн төлөвлөгөөгөө ямар хугацаанд гаргадаг вэ?	.	.009	.415
	30. Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?	.009	.	.441
	26. Та хэддүгээр курсын оюутан бэ?	.415	.441	.
N	24. Та санхүүгийн төлөвлөгөөгөө ямар хугацаанд гаргадаг вэ?	250	250	250
	30. Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?	250	250	250
	26. Та хэддүгээр курсын оюутан бэ?	250	250	250

Coefficient Correlations^a

Model		26. Та хэддүгээр курсын оюутан бэ?	30. Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?
1	Correlations	26. Та хэддүгээр курсын оюутан бэ?	1.000
		30. Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?	.009
	Covariances	26. Та хэддүгээр курсын оюутан бэ?	.001
		30. Та ямар мэргэжлээр суралцдаг вэ?	4.915E-6
a. Dependent Variable: 24. Та санхүүгийн төлөвлөгөөгөө ямар хугацаанд гаргадаг вэ?			

Иргэд олон нийтээс авсан судалгаанд нийт 105 хүн оролцсон бөгөөд хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалт, зан төлөвийг чухалчилж судалсан. Иргэдийн нийт 50% буюу тал нь богино хугацааны санхүүгийн шийдвэр гаргалтыг төлөвлөдөг байна. Мөн ихэвчлэн мөнгөө хадгаламж ба түрүүвчиндээ хадгалдаг.



Мөн амжиргааны зардалаа нөхөц чадахгүй тохиолдол гардаг ажээ. Энэхүү судалгаанд 25-35 насны хүмүүс хамгийн их буюу 30% эзлэн оролцсон байна.

Иргэдийн гол мэдээлэлээ авдаг суваг нь нийгмийн сүлжээ бөгөөд 47.3%-ийг эзэлж байна. Харин оюутнуудын хувьд 42% нь их дээд сургуулийн хичээлээс санхүүгийн мэдээллийг авдаг.

Дүгнэлт

Судалгааны үр дүнд судалгаанд оролцсон оюутнууд нь бидний явуулсан хувь хүний санхүүгийн анхан шатны мэдлэг шалгах асуултын 63 орчим хувьд нь зөв хариулсан байна. Энэ нь оюутнуудын анхан шатны мэдлэг харьцангуй сайн байгааг харуулж байгаа ч хангалттай гэсэн үг бас биш юм. Тиймээс одоо хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөө улам сайжруулах хэрэгцээ шаардлага байна. Үүний тулд монгол банкны зүгээс явуулж буй хувь хүний санхүүгийн хичээлийн сэдэв болон хөтөлбөрийг онолын гэхээсээ илүүтэйгээр практикын жишээ болон кейс ажилбаруудаар дүүргэж болох юм. Үүнээс гадна төрөөс бодлогоор дэмжин мэргэжлийн чиглэл харгалзахгүйгээр бүх их сургуулиудад хувь хүний санхүүгийн талаарх хичээлийг заавал судлах хичээлд нь багтаан, батлах хэрэгтэй. Цаашлаад монгол банкны сурах бичгээс гадна олон улсын стандарт мэдлэг түгээх шилдэг номыг улсдаа нэвтрүүлэн, тэдний сургалтын хөтөлбөрийг ч оруулж ирж болох юм. Судалгаанд хамрагдсан хүмүүс санхүүгийн талаарх мэдээллийн сурвалж дутмаг гэж үзэж байсан бөгөөд тэд энэ талаарх мэдээллийг цахим контент хэлбэрээр болон хөлөгт тоглоомон хэлбэрээр хүлээж авах бодолтой байдаг байна. Үүнээс үзэхэд мэдээллийн эх сурвалжуудыг төрөлжүүлж олон нийтэд болон оюутнуудад хүртээмжтэй болгохын тулд санхүүгийн боловсролд зориулсан тусгай веб сайт ажиллуулах, судлаачдад зориулсан санхүүгийн боловсролын өгөгдлийн сан, өрхийн санхүүгийн шийдвэр гаргалтын сан зэргээр мэдээллийн эх сурвалжуудаа өргөтгөх шаардлагатай гэж үзэж байна.

ЗӨВЛӨМЖ

Санхүүгийн сургалт, мэдээллийг хүргэж болох сувгууд

Нэр	Тайлбар	Судалгааны хувь
Тэнхимийн сургалт	Энэхүү аргаар сургалт зохион байгуулах нь хүртээмжтэй бөгөөд зохион байгуулалтаар нөлөөлөл харьцангуй их байх магадлалтай.	23.2%
Онлайн сургалт	Цаг зав хэмнэсэн шийдэл. Хаанаас ч хүссэн хүн хоорондоо холбогдоход хялбар	14.8%
Теле хэлбэрээр хүргэх	Олон нийтэд хүртээмжтэй хүргэх арга зам болж болно	1.6%
Контент хэлбэртэй	Судалгаанд оролцогчдийн дийлэнх хувь нь энэхүү арга замыг сонгосон байна. Нийгмийн сүлжээгээр хүмүүс мэдээллээ авдаг нь бидний судалгаанаас тодорхойлогдсон.	42.8%
Санхүүгийн холбогдолтой хөлөгт тоглоом	Идэвхжүүлэлтийг хөгжилтэй байдлаар сайжруулна	3.2%
Санхүүгийн холбогдолтой гар утасны тоглоом	Хэрэглэхэд хялбар анхаарал татах боломжтой	5.2%
Санхүүгийн апп	Мэдээллийн суваг чанаржсанаар зөв мэдээллийг цаг алдалгүй авах боломжтой.	9.2%

Ном зүй

- Delpachitra, B. a. (2003). Retrieved from ecosoc.org.au: <http://www.ecosoc.org.au/cc/economic-papers-journal-applied-economics-and-policy>
- Education, N. E. (2021). *National Endowment for Financial Education*. Retrieved from National Endowment for Financial Education: <https://www.nefe.org/about/our-mission.aspx>
- Fikret Er, A. Ö. (2017). Financial Literacy among University Students. *Financial Literacy among University Students: A Case Study for Open*, 2551.
- Gappinger, G. a. (2008). *Financial literacy instruction to adults*. Retrieved from <http://6aa7f5c4a9901a3e1a1682793cd11f5a6b732d29.gripelements.com/pdf/10-book-review-rebecca-travnichek-192.pdf>
- institute, E. i. (2019). Retrieved from institute.eib.org: <https://institute.eib.org/2019/09/financial-education-in-greece/>
- Jeremy Burke, J. M. (2020). Does State-mandated Financial Education Affect Financial Well-being? *Does State-mandated Financial Education Affect Financial Well-being?*, 2-4, 18.
- Lusardi, A. (2019). Swiss Journal of Economics and Statistics. *Swiss Journal of Economics and Statistics*, 4.
- Mohd Zamri, A. B. (2020). Journal of Asian Finance, Economics and Business Vol 7 No 6 (2020) 525 – 535. *Prudent Financial Management Practices among Malaysian Youth:*, 530-532.
- Mouna Amari, B. S. (2020). Financial education effect on saving behavior. *Evaluating the effects of sociodemographic characteristics and financial education on saving behavior*, 2-3.
- National Center for Education Statistics (NCES). (2017). Retrieved from <https://nces.ed.gov/>
- Ömer Alkan, E. O. (2020). Asian Economic and Financial Review. *DETERMINATION OF FACTORS AFFECTING THE FINANCIAL*, 536-539.
- Rispparmio, M. D. (n.d.). *Musseo Del Rispparmio*. Retrieved from Musseo Del Rispparmio: <https://www.museodelrispparmio.it/money-learning-2/>
- Setiawan, B. (2020). Descriptive Analysis of Financial Literacy: Evidence. *SRIWIJAYA INTERNATIONAL JOURNAL OF DYNAMIC*, 73-74.
- site, E. i. (2020). h. *financial*, 1.
- UniRank. (2021). *UNIRANK*. Retrieved from <https://www.4icu.org/>
- Urban, C. (2020). Financial Education in High Schools America. *Financial Education in High Schools America*, 1-2.
- Wilson, M. a. (2000). Conceptualising financial literacy. *Conceptualising financial literacy Loughborough University 41*. Retrieved from https://repository.lboro.ac.uk/articles/preprint/Conceptualising_financial_literacy/9494978

- банк, М. (2017, 4 4). *Mongolbank.mn*. Retrieved from Монголбанк - Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв: <https://www.mongolbank.mn/news.aspx?id=1477&tid=1>
- банк, М. (2017). *Төсөвчин аппликейшн*. Retrieved from Mongolbank.mn: <https://www.mongolbank.mn/news.aspx?id=1477&tid=1>
- банк, М. (2019). *Монгол банк*. Retrieved from <https://www.mongolbank.mn/>
- банк, Х. (2017). *Нийгмийн хариуцлага*. Retrieved from Хас банк : <https://www.xasbank.mn/page/social-responsibility>
- Голомт, Б. (2021). *Finedu*. Finedu: <https://edu.golomtbank.com/>-ээс Гаргасан
- Д.Оюунцэцэг. (2019). *санхүүгийн боловсрол*. [sanhuugiinbolovsrol.mn: https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf](https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf)-ээс Гаргасан
- Монгол банк. (2015). Эдийн засаг, санхүүгийн тайлбар толь. м. банк-Д, *Эдийн засаг, санхүүгийн тайлбар толь* (хүүд. 118). Улаанбаатар. [mongolbank.mn](https://www.mongolbank.mn/).-ээс Гаргасан
- Монгол банк. (2021). *Санхүүгийн боловсрол*. Retrieved from [sanhuugiinbolovsrol.mn](https://www.sankhuugiinbolovsrol.mn/): <https://www.sankhuugiinbolovsrol.mn/cdn/pdf/Huvi%20hun%20buleg1.pdf>
- Монгол улсын хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай. (1994). *Legalinfo*. Retrieved from [Legalinfo.mn](https://www.legalinfo.mn/): <https://www.legalinfo.mn/law/details/383>
- Монгол, Б. (n.d.). Олон нийтийн санхүүгийн сүүр мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр. 2015.
- О.Ирвэс. (2019). *Санхүүгийн боловсрол*. Retrieved from [sanhuugiinbolovsrol.mn: https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf](https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf)
- Оюунчимэг, Ж. (2019). *санхүүгийн боловсрол*. [sanhuugiinbolovsrol.mn: https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf](https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf)-ээс Гаргасан
- П.Баянсан. (2019). *Санхүүгийн боловсрол*. [sanhuugiinbolovsrol.mn: https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf](https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/19.pdf)-ээс Гаргасан
- хороо, С. з. (2013). *Санхүүгийн зохицуулах хороо*. Retrieved from Санхүүгийн зохицуулах хороо: <http://www.frc.mn/>
- Хүүхдийн эрх | UNICEF Монгол. (2019). Retrieved from Хүүхдийн эрх | UNICEF Монгол: https://www.unicef.org/mongolia/mn/topic/%D1%85%D2%AF%D2%AF%D1%85%D0%B4%D0%B8%D0%B9%D0%BD-%D1%8D%D1%80%D1%85?items_per_page=50